



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/156

Мандалговь

“Арматурын байрлал, хамгаалалтын үе тогтоогч
тоног төхөөрөмжийг хүлээлцэх ажлын
комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 11.4, 16.3 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хэрэгцээнд арматурын байрлал, хамгаалалтын үе тогтоогч тоног төхөөрөмж” нийлүүлэх ажлын хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Энхмэнд (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Д.Эрдэнэболд (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ерөнхий нягтлан бодогч)

Э.Эрдэнэсүх (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын өмчийн бодлого зохицуулалт, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Б.Ууганболд (“Монтех Дистрибьюшн” ХХК-ийн гүйцэтгэх захирал)

Хоёр. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хэрэгцээнд арматурын байрлал, хамгаалалтын үе тогтоогч тоног төхөөрөмжийг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Н.Эрдэнэ-Очир)-д даалгасугай.

ДАРГА  Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060667